

Б. Дэлгэрсайхан, СЭЗДС докторант
delgersaikhan.b@ife.edu.mn
Г.Нарантунгалаг, СЭЗДС докторант
narantungalag.g@ife.edu.mn
П. Доржпүрэв, СЭЗДС
dorjpurev.b@ife.edu.mn

НЯГТЛАН БОДОХ БҮРТГЭЛИЙН ХӨГЖИЛД СОЁЛЫН ҮЗҮҮЛЭХ НӨЛӨӨ

Absract

This study attempts to test the theory developed by Gray (1988) linking accounting values and systems with Hofstede's (1980) cultural values of Mongolia. The analysis provides results of comparative researches by foreign countries.

In recent years, many researchers have been engaged in studying relation between culture factors and accounting value internationally.

In the previous paper, we examined the cultural characteristics of Mongolia based on the Hofstede's six cultural dimensions to determine the unique and characteristics of Mongolia that impacts on Gray's four accounting values. The study proposes relationship between identified cultural characteristics and the development of accounting systems. In addition, an accounting profile is developed for Mongolia based on cultural accounting values derived by Gray from Hofstede's dimensions. Profile is created and to proposed to independent IFRS favorable profile by Borker (2013). The study indicates that Mongolian accounting profile fit to the IFRS favorable profile, therefore successful and sustaining IFRS implementation in Mongolia is important factor for meeting its' long-term growth projections.

Key word: *accounting, culture, Hofstede, Gray*

Хураангуй

Уг судалгааны хүрээнд Монгол улсын үндэсний соёлын онцлогоос хамаарч нягтлан бодох бүртгэлийн үнэт зүйлсийг тодорхойлсон бөгөөд гадаадын орнуудад хийгдсэн судалгааны үр дүнг харьцуулан дүгнэлт гаргасан ажил юм.

Өнөөдөр аливаа улс орны нягтлан бодох бүртгэлийн систем, үнэт зүйлсийг судлахдаа үндэсний үнэт зүйлсийн хэмжүүрүүдийг авч үзэх нь чухал болохыг олон судлаачид дүгнэж байна.

Соёл хоорондын харьцуулалт хийх боломжтой Хофстедийн судалгааны аргаар Монголчуудын үнэт зүйлсийн 6 хэмжүүрийг нарийвчлан тодорхойлсон судалгааны үр дүнд тулгуурлан судлаач Грайн гаргасан нягтлан бодох бүртгэлийн үнэт зүйлийн 4 хэмжүүрүүдийн хоорондын хамааралыг тодорхойлсон болно. Түүнчлэн судлаач Боркерийн СТОУС-ийг хөгжүүлэхэд нягтлан бодох бүртгэлийн үнэт зүйлс ямар байх нь нийцтэй байдаг талаар олон оронд хийсэн судалгааны үр дүнд тулгуурлан Монгол улсын хувьд харьцуулалт хийж дүгнэв. Манай улсын хувьд тодорхойлсон нягтлан бодох бүртгэлийн үнэт зүйлс нь СТОУС-ийг хэрэгжүүлэхэд нийцтэй болох нь тодорхойлогдсон ба цаашид бүртгэлийн стандартыг хөгжүүлэхэд анхаарах шаардлагатай болохыг онцгойлон дүгнэв.

Түүнчлэн нягтлан бодох бүртгэлийн хувьд мэргэжлийн ур чадварт тулгуурласан шийдвэрийг чухалчлах, уян хатан байдал, өөдрөг байдал, ил тод байдлыг гол үнэт зүйл болгон төлөвшүүлэхэд боловсролын байгууллага, мэргэжлийн институтууд илүүтэй анхаарах хэрэгтэй гэж дүгнэв.

Түлхүүр үг: *Нягтлан бодох бүртгэл, соёл, Хофстэд, Грай*

Оршил хэсэг

Нягтлан бодох бүртгэл бизнесийн хэл болж өнөөгийн хууль эрх зүй, нийгэм, эдийн засгийн хөгжилд чухал байр суурь эзлэх мэдээллийн системийн нэг хэсэг болон хөгжжээ. Элиот болон бусад судлаачдын хэлснээр “бизнесийн байгууллага өөрийн хэрэглэгчидтэйгээ санхүүгийн мэдээллээр харилцах урлаг нь нягтлан бодох бүртгэл юм. Удирдлагын хяналтын

дагуу эдийн засгийн нөөцийг мөнгөөр харуулж буй санхүүгийн тайлангууд нь ерөнхийдөө харилцаа юм. Тиймээс тус мэдээллүүд нь тухайн хэрэглэгчидтэй хамааралтай байхаас гадна үнэн зөв байхад оршино” гэжээ.

Дэлхий дахины өрсөлдөх чадварын судалгааны үр дүнгээс харахад санхүүгийн тайлагнал болон санхүүгийн бүртгэлийн давуу талын үзүүлэлтүүдээр сүүлийн 12 жилийн туршид бусад улс орнуудаас доогуур түвшинд байна. Түүнчлэн 2015 онд Эдийн засгийн ил тод байдлыг дэмжих тухай хуулийн хэрэгжилтээр ДНБ-ийг 2 дахин тооцсонтой тэнцүү дүнгээр орлого тайлагнасан байна. Эдгээрээс харахад манай улсын хувьд нягтлан бодох бүртгэлийн системийн хөгжлийн түвшин хангалттай бус байгаа төдийгүй хөгжүүлэх хэрэгцээ шаардлага өндөр гэж үзэж болохоор байна. Тэр дундаа аливаа улс орны нягтлан бодох бүртгэлийн системийн хөгжилд нягтлан бодох бүртгэлийн үнэт зүйлс чухал ач холбогдолтой гэж үздэг.

Олон жилийн туршид нягтлан бодох бүртгэлийн чиглэлээр хийгдсэн судалгаанууд нь улс орнуудын нягтлан бодох бүртгэлийн систем болон арга аргачлалтуудын ялгааг харьцуулсан байдлаар хийгдэж ирсэн бөгөөд тухайн нийгмийн үнэт зүйл, түүх, соёлтой холбоотой судалгаанууд тун ховор байжээ. Гэтэл улс үндэстний соёл нь нягтлан бодох бүртгэлийн системийн ялгаатай байдалд нөлөөлдгийг тодорхой судалгаанууд баталж байна. Mueller, Gernon, & Meek нар нь 1994 онд “Нягтлан бодох бүртгэл нь орчны нөлөөллөөр хэлбэрээ олдог. Улс орон бүр өөрийн гэсэн түүх соёл, үнэт зүйлс болон улс төрийн системтэй байдаг тул нягтлан бодох бүртгэлийн хөгжил харилцан адилгүй байна” гэж үзсэн бөгөөд соёл бол нягтлан бодох бүртгэлийн практикт чухал нөлөө үзүүлнэ гэсэн дүгнэлтийг гаргажээ.

Соёл хоорондын хөндлөн харьцуулалт хийх боломжтой үндэсний соёлын судалгааны гол төлөөлөгч болох Гийрт Хофстедийн судалгаанд суурилан судлаач Грэй нь нягтлан бодох бүртгэлийн үнэт зүйлс нь улс үндэсний соёлын хэмжүүртэй хамааралтай болохыг тогтоож, тодорхой онол арга зүйг боловсруулан гаргажээ.

Иймээс энэхүү судалгааны ажлын хүрээнд дээрх аргачлалыг ашиглан үндэсний соёлын хэмжүүрийг тодорхойлсон судалгаанд тулгуурлан Монгол улсын нягтлан бодох бүртгэлийн үнэт зүйлсийг тодорхойлох ажлыг хийж гүйцэтгэв.

Судалгааны ажлын зорилго:

Үндэсний соёл болон нягтлан бодох бүртгэлийн үнэт зүйлс, тэдгээрийн хоорондын холбоог тодорхойлсон онолын судалгаанд тулгуурлан Монголчуудын үндэсний соёлын хэмжүүрийг Гийрт Хофстедийн тодорхойлсон аргаар хэмжиж, түүнд тулгуурлан нягтлан бодох бүртгэлийн үнэт зүйлийг тодорхойлон, холбогдох дүгнэлт, зөвлөмжийг боловсруулах зорилготой.

Үндсэн хэсэг

Хофстэд болон Грайгийн загвар

Соёл хэмээх ухагдахуун нь өргөн хүрээнд хэлэлцэгдэг асуудал бөгөөд шинжлэх ухааны салбар бүр өөр өөрийн байдлаар тодорхойлсон байдаг. Соёл судлаач Б.Сумъяа (Сумъяа, 2001) Соёл нь өөртөө тодорхой бүлгийн гишүүдэд байдаг үнэт зүйлсийг, тэдгээрийн дагаж мөрддөг хэм хэмжээг болон үйлдвэрлэж байдаг материаллаг эд баялгийг өөртөө багтаадаг. Үнэт зүйлс нь хийсвэр эрхэмлэл болж байдаг бол хэм хэмжээ нь хүмүүсийн заавал дагаж мөрдөх ёстой тодорхой зарчим, дүрэм журам юм. (Giddens, 2006)

Хофстэд соёлыг тодорхойлохдоо “ хүмүүсийн нэг бүлэг бусдаас ялгарах оюун санааны нэгдсэн програмчлал” гэжээ. (Hofstede, 2001) Тэрээр дэлхийн ялгаатай болон төсөөтэй соёлуудыг илэрхийлж болохуйц зургаан соёлын хэмжүүрийг тодорхойлсон. Үүнд:

1. Эрх мэдлийн ялгаа заагийг хүлээн зөвшөөрөх түвшин

Байгууллага болон институцүүд дэх эрх мэдэл тэнцвэртэй байдаггүй гэдгийг нийгмийн бүх гишүүд хүлээн зөвшөөрсөн хандлагыг энэхүү хэмжүүр тайлбарладаг. Эрх мэдлийн ялгаа өндөртэй нийгэмд хүн бүр шаталсан удирдлагын дагуу өөр өөрийн байр суурьтай байх ба энэ нь тэр бүр эвдэгдэхгүй. Харин эрх мэдлийн ялгаа багатай нийгмийн хувьд эрх мэдлийн тэгш бус байдлыг анхаарч үзэх бөгөөд эрх мэдэл тэнцвэрийн араас хүмүүс тэмцэж байдаг. Энэхүү хэмжүүрийн гол мөн чанар нь хүмүүс өөр хоорондын тэгш бус байдлыг хэрхэн зохицуулж байна гэдэгт оршино.

2. Тодорхойгүй байдлаас зугатах түвшин

Энэ хэмжүүр хувь хүмүүсийн тодорхойгүй эсвэл мэдэхгүй асуудлаас эмээх мэдрэмжийн түвшинг илэрхийлдэг. Тодорхойгүй байдлаас зугатах түвшин өндөртэй нийгэм дүрэм журмыг чанд баримтлахыг хүсдэг ба сүсэг бишрэлгүй зан төлөв болон санаануудад хэт улайрдаг. Харин тодорхойгүй байдлаас зугатах түвшин багатай нийгэмд зарчмаас илүү практикийг чухалчилж, илүү тайван байх хандлагатай байдаг. Энэхүү хэмжүүрийн үндсэн гол асуудал бол ирээдүйг хэзээ ч мэдэж чадахгүй бөгөөд үүнд нийгэм хэрхэн хариу үйлдэл үзүүлж байна гэдгийг хардаг. Нэг үгээр хэлбэл ирээдүйг хянахыг оролдож байна уу эсвэл энэ болох л ёстой зүйл гэж харж байна уу гэдгийг илэрхийлнэ.

3. Бие даасан эсвэл хамтач байдал

Индивидуализм нь хувь хүмүүс өөр өөрийгөө халамжлахыг зорьдог бол эсрэгээр коллективизм нь хувь хүмүүсийн нийгмийн бүлэг, хамаатан садан эсвэл тухайн бүлгийнхээ гишүүдэд ямар ч хариу нэхэхгүйгээр харж хандахыг хэлнэ.

4. Маскулин эсвэл феминин

Маскулин соёл гүйцэтгэлийн уламжлалт үнэт зүйл болох амжилтанд тэмүүлсэн, баатарлаг байдал, өөртөө игэлтэй байдал болон материаллаг амжилтанд тулгуурладаг бол феминин соёл нь сул доройдоо туслах, амьдралын чанар, даруу байдал болон хамтын ажиллагаанд тулгуурладаг байна.

5. Урт эсвэл богино хугацааны хандлага

Богино хугацааны хандлагатай нийгэм абсолют үнэнийг тогтооход хүчтэй анхаарал хандуулдаг ба тэдний бодол санаа норматив. Тэд уламжлалаа хүндэтгэх боловч ирээдүйг хамгаалах сонирхол бага ба хурдан гарах үр дүнг чухалчилдаг. Харин урт хугацааны хандлагатай нийгэмд хүмүүс үнэн тухайн асуудал, цаг хугацаа, нөхцлөөс шалтгаалдаг гэдэгт итгэдэг. Тэд уламжлалаа өөрчлөх чадвартай ба амжилтанд хүрсэн үр дүнд шаргуу хөдөлмөр, хөрөнгө оруулалтанд хүчтэй сонирхол нь оршдог.

6. Чөлөөт эсвэл баригдмал


Чөлөөт нийгэм хүмүүсийн амьдралдаа сэтгэл хангалуун, зугаа цэнгэлтэй байхыг хүлээн зөвшөөрдөг. Баригдмал нийгэм хүмүүсийн амьдралын баяр баясгалан, зугаа цэнгэлийг нийгмийн хүчтэй хэм хэмжээ, дүрэм журмаар хязарлаж байдаг.

Соёл хоорондын хөндлөн харьцуулалт хийх боломжтой Хофстедийн арга нь хамгийн олон эш татагдсан (Charles, et al., 2014), хамгийн өргөн хэрэглэгддэг (Boonghee, Naveen, & Tomasz, 2011), (Bo, et al., 2013), сайн танигдсан (Kats, Emmerick, John, & Svetlana, 2010), нийгмийн ухаан, менежментийн чиглэлийн олон соёлын харьцуулсан судалгаанд өргөнөөр ашиглагддаг (Graham, 2010), (Boonghee, Naveen, & Tomasz, 2011), (Habe, 2010), соёлын гол үнэт зүйлсийг гаргаж ирж чадсан (Boonghee, Naveen, & Tomasz, 2011), судалгааны үр дүн улс орны хүн амзүй, газарзүй, эдийн засаг, улс төрийн индикатортой хамаарал өндөр гэж судлаачид дүгнэжээ.

Нягтлан бодох бүртгэлд Хофстэдийн үндэсний соёлын хэмжүүрүүдийг чухалчилж авч үзэх нь үндэсний соёл нягтлан бодох бүртгэлийн практикт нөлөөлдөг үздэгт оршино. Грайн (1988) судалгаагаар нягтлан бодох бүртгэлд соёлын хэмжүүрүүд болох бие даасан болон хамтач байдал, эрх мэдлийн ялгаа, тодорхойгүй байдлаас зугтах түвшин илүү хүчтэй хамааралтай байдаг гэж үзжээ. Жишээлбэл тодорхойгүй байдлаас зугатах түвшин өндөртэй улс оршин аль болох ирээдүйн тодорхойгүй байдлаа багасгахын хүсдэг. Энэ нь нягтлан бодох бүртгэлийн хууль дүрэм, журам илүү нарийвчилсан, тогтвортой байхыг зорьдог байна.

Хофстэдийн загварыг Грайн 1988 онд улс орны нягтлан бодох бүртгэлийн системийн хөгжлийн шинжилгээ загвар боловсруулахдаа ашигласан байна. Үүнд нийгмийн үнэт зүйлс нягтлан бодогчдын үнэт зүйлд нөлөөлдөг. Харин гадаад болон хүрээлэн буй орчин болон гадаад нөлөөллөөс нийгмийн үнэт зүйлс хэлбэрээ олдог байна. Тиймээс нягтлан бодох бүртгэлийн үнэт зүйлс нягтлан бодох бүртгэлийн системд нөлөөлдөг бөгөөд соёлын хүчин зүйл улс орны түвшинд санхүүгийн системд нөлөөлж байгаа хамаарлыг доор Дүрслэл 1-т харуулав.

Дүрслэл 1. Грайн (1988) үндсэн загвар



Hofstede-н соёлын хэмжүүрийг ашиглан Gray доор дурдсан НББ-ийн дөрвөн хэмжүүрийг тодорхойлсон байна. Үүнд:

1. *Мэргэжлийн ур чадварт суурилсан шийдвэр эсвэл хууль эрхзүйд суурилсан шийдвэр* – аливаа асуудалыг шийдвэрлэхдээ мэргэжлийн ур чадвараа ашиглахыг илүүд үзэх, эсвэл хуулийн хүрээнд шийдвэрлэхийг чухалчилах 2 хэлбэрийг эсрэгцүүлнэ

2. *Тогтсон хэв маяг эсвэл уян хатан хэв маяг* – байгууллагын НББ хөтлөлд нийтээр хүлээн зөвшөөрөгдсөн тогтсон бодлогыг баримтлах, эсвэл байгууллагын онцлогт тохирсон онцлогтой бодлогыг баримтлах 2 хэлбэрийг эсрэгцүүлнэ

3. *Хуучинсаг үзэл эсвэл өөдрөг үзэл* – ирээдүйд болох аливаа үйл явдалд болгоомжилсон өнцгөөс хандах, эсвэл илүү эрсдэлтэй, өөдрөг өнцгөөс хандах 2 хэлбэрийг эсрэгцүүлнэ

4. *Нууцлал эсвэл ил тод байдал* – НББ-ийн аливаа мэдээллийг зөвхөн тухайн байгууллагын холбогдох эрх бүхий албан тушаалтнуудад толилуулах, эсвэл олон нийтэд нээлттэйгээр толилуулах 2 хэлбэрийг эсрэгцүүлнэ

Дээрх НББ-ийн үнэт зүйлс Hofstede-н соёлын үнэт зүйлсийн хоорондын хамаарлыг доорх хүснэгтэд харуулав:

Baydon, Willet (1995) нар Hofstede-н соёлын хэмжүүр болон Gray-н НББ-ийн хэмжүүр хоорондын харилцан хамаарлыг (+) “шууд хамааралтай”, (-) “урвуу хамааралтай” гэж тэмдэглэсэн байна. Borker АНУ, Их Британи, Австрали, Канад болон Шинэ Зеландад хийсэн судалгааныхаа үр дүнд үндэслэн Hofstede-н соёлын хэмжүүр болон Gray-н НББ-ийн хэмжүүр хоорондын харилцан хамаарлыг тодорхойлохдоо Hofstede-н соёлын хэмжүүрийн 5 дахь хэмжүүр болох “Урт хугацааны чиг хандлага” болон 6 дахь хэмжүүр болох “Хориг ба хүлцэнгүй байдал” зэргийг нэмж өргөтгөсөн байна.

Хүснэгт №1. Хофстэдийн соёлын хэмжүүрүүд болон Грайн Нягтлан бодох бүртгэлийн хэмжүүрүүдийн хоорондын хамаарал

	Эрх мэдлийн ялгаа заагийг хүлээн зөвшөөрөх түвшин	Бие даасан эсвэл хамтач	Маскулин болон феминин	Тодорхойгүй байдлаас зугатах түвшин	Урт эсвэл богино хугацааны хандлага	Чөлөөт эсвэл баригдмал
Хуучинсаг үзэл	+	-	-	++	+	-
Тогтсон хэв маяг	+	--	?	++	+	-

Мэргэжлийн ур чадвар	-	++	?	--	-	+
Нууцлал	++	--	-	++	+	-

Судалгааны хэсэг

СЭЗДС-ийн үнэт зүйлийн судалгааны багийн 2015 онд Үндэсний үнэт зүйлийн судалгааг дээрх аргаар хийж гүйцэтгэсэн бөгөөд нийтдээ 4024 хүний түүвэртэйгээр судалж, дараах индексүүдийг тооцож гаргасныг хүснэгт2-т харуулав. (Ганбат, бас бус., 2015)

Хүснэгт 2. Хофстэдийн соёлын 6-н хэмжүүрийн үр дүн. Монгол улс

PDI	IDV	MAS	UAI	LTO	IVR
Эрх мэдлийн ялгаа заагийг хүлээн зөвшөөрөх түвшин	Бие даасан эсвэл хамтач	Маскулин болон феминин	Тодорхойгүй байдлаас зугатах түвшин	Урт эсвэл богино хугацааны хандлага	Чөлөөт эсвэл баригдмал
62	48	55	0.4	32	76

Хофстэдийн соёлын хэмжүүрийн үр дүнд суурилж Грайн нягтлан бодох бүртгэлийн үнэт зүйлийн хэмжүүрүүдийг хүснэгт 1-ийн дагуу шинжилгээ хийж гаргасан үр дүнг хүснэгт 3-т харуулав.

Хүснэгт 3. Грайн Нягтлан бодох бүртгэлийн үнэт зүйлийн хэмжүүрийн үр дүн: Монгол улс

Хэмжүүр	Монгол
Мэргэжлийн ур чадварт суурилсан шийдвэр эсвэл хууль эрхзүйд суурилсан шийдвэр	Мэргэжлийн ур чадварт суурилсан шийдвэр
Тогтсон хэв маяг эсвэл уян хатан хэв маяг	Уян хатан хэв маяг
Хуучинсаг үзэл эсвэл өөдрөг үзэл	Өөдрөг үзэл
Нууцлал эсвэл ил тод байдал	Ил тод байдал

Дээрх үр дүнгээс бид Монгол улсын нягтлан бодох бүртгэлийн үнэт зүйл илүү мэргэжлийн ур чадвар суурилж шийдвэр гаргах, компани бүр өөрийн нөхцөл байдалд суурилах, эрсдэлээс айхгүй байх болон нээлттэй бүртгэлийн арга хандлагыг ашиглах хандлагатай гэж дүгнэлээ.

Үүнээс гадна Воркер (2013) хийсэн нэгэн чухал үнэлгээ бол АНУ, Их Британи, Австрали, Канад болон Шинэ Зеландад хийсэн судалгааныхаа үр дүнд үндэслэн СТОУССтандартыг баримтлахад тохиромжтой соёлын хэлбэрийг Грау-н НББ-ийн үнэт зүйлсэд суурилан тодорхойлсон явдал юм. Уг үнэлгээг доорх хүснэгтэд харуулав.

Грау-н НББ-ийн үнэт зүйлс	СТОУС-г баримтлахад тохиромжтой хэлбэр
Мэргэжлийн ур чадварт суурилан шийдвэр гаргах ба хууль эрхзүйд суурилан шийдвэр гаргах	Мэргэжлийн ур чадварт суурилан шийдвэр гаргах
Тогтсон хэв маяг ба уян хатан хэв маяг	Уян хатан хэв маяг
Хуучинсаг үзэл ба өөдрөг үзэл	Өөдрөг үзэл
Нууцлал ба ил тод байдал	Ил тод байдал

Дүгнэлт

Монгол улсын нягтлан бодох бүртгэлийн үнэт зүйлийг Гийрт Хофстедийн аргачлалд тулгуурласан Грайн аргачлалаар судалж дараах дүгнэлтүүдийг гаргалаа.

- Аливаа улс орны нягтлан бодох бүртгэлийн систем болон үнэт зүйлст улс орны үндэсний үнэт зүйл нөлөөлдөг болохыг судлаачид нотолсон төдийгүй, сүүлийн жилүүдэд

зөвхөн улс орнуудын системийг харьцуулан судлахаас илүүтэй, нийгмийн үнэт зүйлстэй холбон авч үзэх нь чухал гэж үзэж байна.

- 2015 онд СЭЗДС-ийн үнэт зүйлийн судалгааны багт орж ажиллаж Гийрт Хофстедийн асуулга судалгааны аргаар Монголчуудын үнэт зүйлсийн 6 хэмжүүрийг нарийвчлан тооцож гаргасан болно. Эндээс харахад Монголчууд ажил төрлийн тал дээр илүү бие даасан шинжийг агуулдаг, феминин шинжээс илүүтэй маскулин шинжтэй, богино хугацааны хандлага давамгайлдаг, тодорхойгүй байдлаас зугатах түвшин багатай, эрх мэдлийн ялгаа зааг ялимгүй өндөртэй, чөлөөт байдал нь баригдмал шинжээсээ илүү давамгайлдаг болох нь тодорхойлогджээ.

- Дээрх үр дүнд тулгуурлан Грайн гаргасан нягтлан бодох бүртгэлийн үнэт зүйлсийн 4 хэмжүүрийг тооцож үзэхэд Монголчууд хууль дүрэм журмаас илүүтэй мэргэжлийн ур чадварт суурилан шийдвэр гаргадаг, тогтсон хэв маягаас илүүтэй уян хатан байдлыг чухалчилдаг, хуучинсаг баримтлалаас илүүтэй өөдрөг үзлийг чухалчилдаг, нууцлалаас илүүтэй ил тод байдлыг чухалчилдаг болох нь тодорхойлогдсон юм.

- Судлаач Borker (2013) нь АНУ, Их Британи, Австрали, Канад болон Шинэ Зеландад хийсэн судалгааныхаа үр дүнд үндэслэн СТОУССтандартыг баримтлахад тохиромжтой соёлын хэлбэрийг Gray-н НББ-ийн үнэт зүйлсэд суурилан тодорхойлсон ба үүнд мэргэжлийн ур чадварт тулгуурлах, уян хатан байх, өөдрөг байх, ил тод байх зэргийг СТОУС-ийг баримтлахад хамгийн тохиромжтой гэж дүгнэжээ. Манай улсад хийсэн энэхүү судалгааны үр дүн ч уг үнэт зүйлстэй таарсан бөгөөд нийцтэй болон тохиромжтой үнэт зүйлстэй болох нь тодорхойлогдсон юм. Иймд цаашид стандартын хэрэгжилтийг хангахад илүүтэй анхаарах боломжтой гэж үзэж болохоор байна.

- Түүнчлэн их дээд сургууль, мэргэжлийн институтуудын хувьд дээрх үнэт зүйлсийг дэмжсэн сургалтын хөтөлбөрийг хөгжүүлээд зогсохгүй нийгэмдээ тухайн чиглэлээр манлайллыг хөгжүүлэх нь чухал ач холбогдолтой гэж үзэж байна.

- Нягтлан бодох бүртгэлийн бодлого, шийдвэр гаргалтуудыг сайжруулах, НББ-ийн стандарт, нягтлан бодогчдын сургаж хөгжүүлэхэд ил тод байдал, уян хатан байдал, өөдрөг байдал, мэргэжлийн ур чадварт тулгуурлан шийдвэр гаргах хандлагад тулгуурлах нь чухал гэж үзэж байна.

Ном зүй

1. Baydon, N., & Willet, R. (1995). Cultural Relevance of Western Accounting Systems to Developing Countries. *ABACUS*, 67-92.
2. Borker, D. R. (2013). Is There a Favorable Cultural Profile for IFRS?: Examination and Extension of Gray's Accounting Value Hypotheses. *International Business & Economics Research Journal*, 167-177.
3. Giddens, A. (2006). *Социологи*. Улаанбаатар: НШУС, Социологийн тэнхим.
4. Gray, S. J. (1988). Towards a Theory of Cultural Influence on the Development of Accounting Systems Internationally. *Abacus*, 1-16.
5. Hofstede, G. (2001). *Culture's Consequences: Comparing Values, Behaviors, Institutions and Organizations Across Nations*. Thousand Oaks, CA: Sage Publications.
6. Mueller, G., Gernon, H., & Meek, G. K. (1994). *Accounting: An International Perspective: a Supplement to Introductory*. Illinois: IRWIN Burr Ridge.
7. Нарантунгалаг, Г., Дэлгэрсайхан, Б., Булган, Ц., Гэрэл, Ц., Одгэрэл, А., & Түвшинзаяа, С. (2015). *Монголчуудын үндэсний үнэт зүйлийн судалгаа*. Улаанбаатар: СЭЗДС.